

Монголын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцыг боловсронгуй болгохуй: “үгүй” гэж хэлж чаддаг монгол

Г.Төмөрчулуун*

Алив улсын гадаад бодлого гурван баганад тулгуурладаг. Эхний багана нь мэдээлэл, хоёрдахь нь дүн шинжилгээ, гурав дахь нь шийдвэр байдаг. Эдгээрийн аль нэггүйгээр гадаад бодлогыг төсөөлөхийн аргагүй. Олон улсын харилцааны асуудлыг задлан шинжилж, дүн шинжилгээ хийх чадвар бол хэдэн зуун танкнаас ч илүү хүчтэй зэвсэг байдаг. Монгол шиг хүрээлэлд оршдог улсын хувьд энэ бол бүр чухаг.

Гадаад бодлогын шийдвэрийг алив улс гадаад орчиндоо тулгуурлаж дотооддоо гаргадаг. Гадаад харилцааны бодлогын шийдвэрийн тухай асуудал бол гадаад бодлогод, энэ утгаараа улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд амин чухал ач холбогдолтой байдаг. Шийдвэр гаргах асуудал бол гадаад бодлогод үндэсний эрх ашгийг хэрэгжүүлэх гол элемент мөн бөгөөд гадаад бодлогын шийдвэр гэдэг нь гадаад бодлогыг залж явуулах улс төрийн эрх мэдлийн технологи мөн. Гадаад бодлогын шийдвэр гэдэг маань улс орнуудын өөрийн гэсэн гадаад бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх үндсэн нөхцөл байдаг.

Гадаад бодлогын шийдвэрийн тухай асуудал манайд шинжлэх ухааны талаасаа олигтой судлагдаагүй сэдэв. Өрнө, Дорнын соёл иргэншлүүд энэ талаар баялаг туршлага хуримтлуулсан байдаг.

* Г.Төмөрчулуун ГХЯ-ны Бодлого төлөвлөлт, судалгааны газрын зөвлөх, Улс төрийн шинжлэх ухааны доктор, судалгааны тэргүүлэх профессор

ОЛОН УЛС СУДЛАЛ

Хятадын Сун Цугийн “Дайтах урлаг”, “Гурван улсын түүх”, Эртний Энэтхэгийн Каутила жанжны бүтээлүүд, шинэ түүхийн Махатма Гандийн хүчирхийлэлгүй дэлхий ертөнцийн тухай үзэл бодол, Монголын эзэнт гүрний байлдан дагуулалтын үеийн гадаад бодлогын шийдвэрүүдийг нэрлэж болно.

Орчин үеийн олон улсын харилцааны тухай шинжлэх ухаан 20 дугаар зууны эхнээс АНУ, Англиас үүдэлтэй бол гадаад бодлогын шийдвэрийн тухай шинжлэх ухаан 1960-аад онд АНУ-д үүсч хөгжсөн байдаг. Анхных нь төлөөлөгчид нь Ричард Шнайдр, Жеймс Розено, Грэхэм Эллисон нар юм. Энэ утгаараа гадаад бодлогын шийдвэрийн тухай онол бол цэвэр америк брэнд юм.Зориуд сонирхож үзэхэд Европын Холбооныхон энэ америк брендтэй харьцуулахаар, түүнтэй эн зэрэгцэхээр олигтой хувилбар гаргаагүй юм билээ.Харин оронд нь еврократия гэсэн шинэ нэр томъёо бий болгочихсон юм билээ. Харин ЕХ-ны хүний эрхийн стандарт бол тасархай хөгжсөн байна. Энэ үзүүлэлтээрээ ЕХ АНУ, НҮБ-ыг ч ардаа орхино. Иймд хүний эрхийн асуудал, энэ талын шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулшлагыг нь судлах тал дээр бид ЕХ-г гол түншээ болгох нь зөв байх.

Эдүгээ гадаад бодлогын шийдвэр гаргалтын асуудлыг Монголын хоёр ч их сургуульд албан ёсоор хичээлийн хөтөлбөрт оруулж үзэж байгаа. Энэ бол МУИС-ийн ОУХС (1993 оноос), Хүмүүнлэгийн Их сургууль (2013 оноос) хоёр юм. Эдгээр сургууль олон улсын харилцаа,гадаад бодлогын асуудлаар мэргэшсэн залуу хүмүүсийг бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэх байхаа гэж найдна.

Монголын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцын тухай асуудлыг Гадаад харилцааны яам анхлан гарган тавьж, эл асуудлаар бие даасан ажлын хэсэг байгуулан ажил өрнүүлж байгаа нь туйлын сайшаалтай.

Гадаад бодлого гэж хүн бүр ярьдаг ч үнэндээ түүнийг яаж хийдэг гэдгийг тэр болгон мэддэггүй. Гадаад бодлогын шийдвэрийн үйл явц аль ч улсад цөөн тооны мэргэжлийн хүмүүсийн асуудал байдаг учраас ийм байдаг байж магадгүй.

Зүй нь гадаад бодлогын шийдвэр гэдэг бол тун нарийн төвөгтэй ажиллагаа. Үүнийг хямралын үеийн, жирийн үеийн гэсэн хоёр хэсэгт хувааж үзэх ёстой юм. Олон улсын стандарт талаас авч үзвэл Монголын гадаад бодлогын шийдвэр гаргадаг үйл явц Америк юмуу Европын ийм төрлийн стандартаас нэг их гажаагүй гэж хэлэх ёстой юм.

Учир нь гадаад бодлогын шийдвэр гаргадаг үйл явц ардчилсан улсуудын хувьд адил буюу төсөөтэй байдаг. Гадаад бодлогын шийдвэр гаргадаг байгууллагуудын жишээ нь парламентын, засгийн газрын, ерөнхийлөгчийн эсвэл Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гэх мэтээр эрх мэдлийг нарийвчлан хуульчилсан байдаг.

Гэхдээ л гадаад бодлогын шийдвэр гаргах ажиллагааг боловсронгуй болгож сайжруулах асуудал их байгаа гэж хэлмээр байна.

Шийдвэр гаргалтын үйл явцын үндсэн хэсэг нь мэдээжээр дүн шинжилгээний хэсэг. Дүн шинжилгээ хийх чадвар бол хэдэн зуун нисэх онгоц, танкнаас илүү гайхамшигтай зэвсэг байдаг. Үүнийг ганц хоёр хүн биш, өндөр чадавхитай эрдэм шинжилгээний хүрээлэн л хийж чадна. Өнөөдөр ийм хүрээлэн бидэнд үгүйлэгдэж байна. Харамсалтай нь нэг нь байгуулдаг нөгөө нь устгадаг нь Монголын бичигдээгүй хууль хойно. 1999 онд Н.Туяа гэдэг сүрхий боловсролтой сайд ийм төвийг гадаад яамны түүхэнд анх удаа байгуулсан ч дараа нь түүнийг устгацгаасан. Тэр төвийг арчлаад бэхжүүлээд байлгаж байсан бол өдийд бид нэлээд өндөрт гарчихсан байх байсан гэж би хувьдаа боддог.

Америкт Гадаад харилцааны Зөвлөл /Форн Афферс Каунсл/ гэж байдаг. Рокфеллер санхүүжүүлдэг. Тэндээс гарсан Киссенжер, Бжежински зэрэг мундгууд АНУ-ын гадаад бодлогод ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг та бид мэднэ.

Ийм “сэтгэгч танк”-ын судлах нэг чухал асуудал бол “мөргөлдөөн судлал” байх ёстой. Оросоор конфликтология буюу англиар “conflict studies” гэх энэхүү сэдэв өдгөө олон улс судлалын үндсэн чиглэл болж байна. Принстоны их сургууль тэр аяараа энэ зүгт судалгаагаа хийж байна.

Үүнтэй холбогдуулан ППП буюу паблик прайват партнершип – ийн асуудал гарч ирнэ. Гадаад харилцааны чухал алхмуудыг дэмждэг хувийн хэвшлийнхэн өнөөдөр биш ч гэсэн маргааш заавал гарч ирнээ. Үүнд итгэх хэрэгтэй. Монгол Макиавелли хэрэгтэй байна шүү дээ.

Шийдврийн дотоод хүчин зүйлийн тухай ярихдаа улс төрийн намууд, засгийн газрын бус байгууллагууд, лоббист бүлгүүд, хэвлэл мэдээллийн хэргэслүүдийн үйл ажиллагааны талаар дурдалгүй өнгөрч болохгүй. Эдгээр байгууллагууд улс төрийн ардчилсан тогтолцоотой алив улсад заавал байх ёстой, нийгмийг боловсронгуй болгоход үйл ажиллагаа нь чиглэгддэг, тэрээр гадаад бодлогын шийдвэрт зохих нөлөө үзүүлж байдаг институтууд юм. Улс оронд ардчилалын үйл явц гүнзгийрэх тутам тэдгээрийн улс төрийн түүний дотор гадаад бодлогод үзүүлэх нөлөө улам нэмэгдэх болно.

Лобби. Гадаад бодлогын шийдвэрт нөлөөлдөг нэг чухал асуудал боляах аргагүй лобби байдаг. АНУ дахь изралийн лобби гэж гайхалтай үзэгдэл байдаг юм билээ. Сонгодог утгаараа Монголд байдаг эсэхийг мэдэхгүй байна. Гэвч манайхны ярьдаг “жалга, дов”-ын үзэл гэдэг нь энэхүү лобби гэсэн ойлголтод ихэд дөхөж очих байх гэж бодно. Нэг аймгийнхан, нэг сумынхан, нэг сургууль төгссөн улсууд гэх мэтээр манайд байдаг үзэгдэл. Харин гадаад бодлого, олон улсын харилцаа гэхээр “прокитайский, прорусский” эсвэл “проамериканский” гэгдэх этгээдүүд гэсэн ойлголтууд байдаг. Энэ бол монгол маягийн ойлголт. Үүнийг хууль гаргаж зохицуулах нь зүйтэй биш байгаа гэсэн сэтгэгдэл төрж байгаа. Ухаандаа “лоббийн тухай хууль” ч гэдэг юм уу. Лоббидах асуудал бол Монгол шиг жижиг улсын хувьд зарчмын асуудал гэдгийг тэмдэглэх ёстой гэж мунхаг би ойлгож байна.

Хэвлэл мэдээлэл. Германы Дер Спигел сонин АНУ-ын тусгай албад холбоотнуудаа хүртэл тагнаж байгаа тухай бичсэн. Францын Ле Монд, Английн Д Гардиан сонин татвараас зайлсхийсэн баячуудын тухай бичиж олон улсын шуугиан дэгдээсэн байна. Вольтер Липманыг мэдэхгүй хүн бараг байхгүй биз. Тэрээр Форен Афферс сэтгүүлийн эрхлэгчээр ажиллаж байхдаа өөрийн бичсэн материалаа тухайн үеийн Америкийн гадаад бодлогыг бараг удирдан жолоодсон гэдэг. Вашингтон Пост сонины хоёр сэтгүүлч Америкийн Ерөнхийлөгчийг

огцруулах хүртэл материал бичиж нийтлүүлсэн жишээтэй. Энэ асуудал хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон улсын харилцаанд ямар чухал үүрэг роль гүйцэтгэж байгааг харуулах баримт юм. Нөгөө талаар гадаад бодлогодоо тунгалаг байхыг сургаж буй хэрэг. Олон улсын харилцаагаар мэргэшсэн сэтгүүлчийн шаардлага их байгааг энэ бас харуулж байна. Тэгэхлээр олон улсын сэтгүүлч бэлтгэдэг сургууль хэрэгтэй болох нь. Гадаад харилцааны яамны дэргэд Дипломатын Академи байгуулна гэдэг нь энэ асуудалтай шууд холбоотой.

Virtual diplomacy, E-Diplomacy буюу “цахим дипломат ажиллагаа” гэдэг нь олон улсын харилцаа, дипломат ажиллагааг цахим мэдээллийн технологи ” –ийн туслалцаатайгаар шийтгэн явуулахыг хэлнэ. Мэдээллийн технологийн эрин өнөө үед бие даасан улс орнууд дангаараа ОУЭЗ- субъект байхаа нэгэнт больж төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхэн, тэр бүү хэл хувь хүн хүртэл ийм статустай болж байна. Өдгөө дэлхийд нэг тэрбум хүн 24 цагийн туршид интернеттэй харьцаж байна. Өнөө үед цахим мэдээллийн технологийг ашиглах нь Жозеп Найын хэлдэг “soft power” буюу “аядуу зөөлөн хүч”-ний салшгүй хэсэг болжээ. Канад улс жишээлэхэд цахим дипломат ажиллагааг “аядуу зөөлөн хүч” болох эрхэм зорилгодоо чадварлаг ашиглаж, энэ тал дээр ихээхэн туршлага хуримтлуулжээ. Өдгөө дэлхийг цэргийг хүчээр биш цахим мэдээллээр байлдан дагуулж байна. Орчин үеийн дипломат үйлд цахим технологийг өргөнөөр ашиглах нь нэн ялангуяа Монгол шиг бага улсад зарчмын ач холбогдолтой. Учир нь жижиг улсын хязгаарлагдмал гадаад харилцааг нөхөх, хүний нөөцийн хомсдолыг арилгах боломжийг цахим технологи олгож байгаа юм. Энд мэдээж мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг бодолцох ёстой.

АНУ, Англи шиг их гүрнүүдийг гүйцэхгүй юм гэхэд Шинэ Зеланд, Эстони зэрэг улсын зиндаанд цахим дипломат үйлцийн хэрэглээ хүрвэл болж байгаа гэж үзэх хэрэгтэй бололтой.

Гадаад бодлогын шийдвэр гаргахад ялангуяа хүний нөөцийн асуудал шийдвэрлэх ач холбогдолтойг тэмдэглэх ёстой. Боловсон хүчинд тавигдах үндсэн шаардлага, чадварын тоонд харь улстай хэлэлцээ хийх чадвар, олон улсын аливаа үзэгдлийг ажиглах, задлан шинжлэх чадвар, улсаа төлөөлөх чадвар, ДТКГ-ын ажлыг зохион

ОЛОН УЛС СУДЛАЛ

байгуулах, менежментээр хангах, удирдах чадвар, хүнтэй харьцах, олон нийтийн дипломат ажиллагаа, түүний дотор ТВ, олон нийтийн мэдээллийн бусад хэрэгслийг улсынхаа зорилгод ашиглах чадвар, харь улсын соёлыг ойлгох чадвар багтана. Монголын дипломатчид дор хаяад гадаадын гурван хэлийг, түүний дотор Азийн нэг хэлийг чөлөөтэй эзэмшсэн байх нь 21 дүгээр зууны Монголын дипломатчид тавигдах чухал шаардлага мөн. Гэвч эдгээр шаардлага бас хангалтгүй. Шийдвэр гаргахад оролцогч дипломатч өөрийн орноо сайн мэддэг, улс төрийн өндөр ухамсартай, хувь хүний хувьд боломжийн, сэтгэлгээний хувьд уян хатан, илүү мэдэхийн төлөө тэмүүлдэг, улсынхаа гадаад бодлогыг томъёолон тодорхойлох сэтгэл зүйн бэлтгэлтэй байх ёстой юм.

Бид гадаад бодлогодоо алийн болгон хүний хэлснийг дагах вэ? Дорвитойхон өөрчлөлтийг хийх хэрэгтэй байна. “Үгүй” гэж хэлж чаддаг Монгол гэхээр дөргүй бух шиг харсан зүг рүүгээ зүтгэхийг хэлээгүй. Монгол Улсын үндэсний эрх ашиг шаардвал үгүй гэж хэлэхээс өөр аргагүй гэсэн санаа.

Монголын гадаад бодлого өөрчлөгдөөд 20 -иод жил өнгөрлөө. Монгол Улсын Гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдснаас хойш ирэх 2014 онд 20 жил болно. Иймд энэ ойг өнгөрснөө эргэн дүгнэж, ирээдүйгээ томъёолоход чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх санал дэвшүүлж байна. Тухайлбал, ойг тохиолдуулан эрдэм шинжилгээний томоохон бага хурал хийж болох юм.

ДТГ-уудын байршлын тухай сэдэв байна. Дорнод, Төв Европын хуучин социалист гэгдэж байсан улсууд Улаанбаатар дахь ЭСЯ-аа хаасан. Бид мөн тийм алхам хийхэд болохгүй гэх газаргүй. Дипломат үйл харилцан адил байх зарчимд тулгуурладаг. Тэд санхүүгийн хувьд бэрхшээлтэй гэж хэлдэг. Монгол Улс тэдгээрээс илүү мөнгөтэй биш шүү дээ. ЭСЯ хааснаас гарах эх үүсврийг өөр газар ЭСЯ байгуулахад зарцуулж болно шүү дээ. Тэд бүгд ЕХ-нд элссэн учир хоёр талын харилцааны асуудлыг Брюсселэс хариуцаж болох юм. Харин Брюсселийг байшин сав, хүний нөөцөөр сайн хангаж өгөх хэрэгтэй юм. Юутай ч тэр жижиг тивд тэр олон ЭСЯ шавааралдаж байх шаардлага одоо байхгүй гэж хувьдаа боддог.

Цаашдаа шинээр ЭСЯ нээхээр бол цаад улс манайд ЭСЯ-аа нээж байхаар анхнаас харилцан тохиролцож байх нь чухал. Улаанбаатар дахь гадаадын ДТГ-уудын тоог аль болох нэмэгдүүлэх бодлого бол бидний стратегийн байнгын эрхэм зорилго байх ёстой. ЕХ-ны ЭСЯ-ыг Улаанбаатарт байгуулах асуудлыг үргэлжлүүлэн хөөцөлдөх ёстой. Хоёрхон сая еврогийн асуудал байдаг юм билээ. Тэр баян байгууллагад хоёр сая евро юу юм бэ?.

Шударга бус хэлэлцээрүүд. Өнгөрсөн жилүүдэд алдсан юмаа цэгцэлж авах хэрэгтэй байна. 1990-ээд онд бид Хөрөнгө оруулалтын тухай, давхар татварын тухай гэсэн хоёр хэлэлцээр байгуулах асуудал эвэртэй тууриатай болгоны амны уншлага болсон байв. Гэтэл миний мэдэх Бенелюксийн 3 улстай байгуулсан ийм хэлэлцээрт тэднээс татвар авахгүй гээд биччихсэн хэлэлцээрт бид гарын үсэг зураад жирийлгэж байсан нь сүүлд тодорхой болж Засгийн газар тэдгээрийг цуцлахыг үүрэг болгосон. Энэ мэтчилэн өөр олон улстай ийм хэлэлцээрүүдийг бас байгуулж байсан шүү дээ.

Түншлэлийн олон хэлэлцээрийг бид байгуулж байгаа. стратегийн, өргөтгөсөн, иж бүрэн, оюун санааны гэх зэрэг. Ямар ялгаатай гэхээр хариулдаг хүн байдаггүй. Эдгээрт ядахдаа тайлбар өгдөг болох хэрэгтэй баймаар.

Өргөмжит консулуудын институцийг цаашдаа ч өргөжүүлэх нь манай шинэчлэлийн бодлогын нэг чухал хэсэг гэж би хувьдаа бодддог. Өдгөө Ази, Латин Америк, Африк руу энэ бодлого маань тэлэх хэрэгтэй байна. ОХУ-тай визгүй зорчих дэглэмд шилжих асуудал бол байнга. Визгүй байсныг бид өөрсдөө л визтэй болгосон юм шүү дээ. Оростой реадмиссийн хэлэлцээрийг байгуулах хэрэгтэй гэж бодож байна. Энэ бол хэн нэг хүний хүслээр хийж байгаа ажил биш олон улсын консулын харилцааны хөгжлийн чиг хандлага тийм байгаа юм.

Хөрөнгө мөнгө, төвлөрсөн төсөв байх. Манайхан олон улсын болон бүс нутгийн байгууллагад элсэн орох гэж бөөн юм болдог мөртлөө орсон хойноо хуралд зөвлөлгөөн, арга хэмжээнд нь оролцдоггүй. Шалтгааныг асуухлаар хөрөнгө мөнгө байхгүй гэдэг. Мөн ийм байгууллагуудад элсчихээд тагвараа төлдөггүй. Намайг

ОЛОН УЛС СУДЛАЛ

Брюссельд ажиллаж байхад Олон улсын эрүүгийн шүүхээс манайхыг татвараа төлсөнгүй гэж байнга бичиг цаас ирдэг байлаа.

Нэг цонх. Гадаад харилцаа зөвхөн гадаад яамны хэрэг байхаа болиод удаж байгаа. Манай дотоодод ардчиллын үйл явц гүнзгийрч олон улсын харилцаа даяаршлагад тусам гадаад харилцааны салбарт оролцон тоглогчдын тоо улам нэмэгдэх болно. Энэ бүхнийг Гадаад яам ганцаараа зангидан захирна гэдэг бол боломжгүй зүйл. Үүнээс гарах гарц олох талаар харин ажиллах ёстой.

Эцэст нь элчин сайдын томилгооны тухай ганц санаа хэлье. Энэ талаархи Европын Холбооны туршлагыг харгалзан үзэж болох мэт. Тэнд элчин сайд нарыг хоёр янзаар томилдог. ЕХ-нд их ач холбогдолтой том улсад суух Элчин сайд нарыг Европын Гадаад харилцааны алба, Европын Комисс, Европын Зөвлөл 27 улсын нэг иргэн-дипломатчийг дээрээс сонгон авч томилдог. Жишээ нь Хятад, Орос, АНУ гэх мэт. Манайд үйлчилдэг системтэй ойролцоо. Харин нөгөө нэг арга нь сонгон шалгаруулалт байдаг. Жишээ нь Шинэ Зеланд, Вьетнамд суух элчин сайд нараа хэн сайн хөтөлбөр гаргана тэр хүнийг томилдог. Энэ бүхнийг ил тодоор Гадаад харилцааны албаны зарлалын самбарт, түүний вэб хуудсанд байрлуулсан байх юм билээ.